



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Өндөрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/087/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Батсүх Утас: 70453799, Цахим хаяг: Batsukht@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв
 - 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн
 - 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ӨНДӨРХАНГАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Я.ГАНБАЯР ТАНАА

2026.02.25 № УВА-2026/087/НА-СТА-ТШС
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050602

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М. БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>419,277,832.82</u>	<u>262,667,158.49</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	340,814,895.31	198,854,992.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	340,814,895.31	198,854,992.00
3121	Төгрөг	340,814,895.31	198,854,992.00
31211	Төрийн сангийн харилцах	340,814,895.31	198,854,992.00
33	АВЛАГА	580,223.90	628,914.88
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	580,223.90	628,914.88
35	БАРАА МАТЕРИАЛ	77,882,713.61	63,183,251.61
351	Түүхий эд материал	18,534,517.13	23,681,215.13
35110	Тусгай зориулалттай материал	18,534,517.13	23,681,215.13
354	Хангамжийн материал	59,348,196.48	39,502,036.48
35410	Бичиг хэргийн материал	150,000.00	150,000.00
35420	Аж ахуйн материал	18,508,658.58	21,282,178.58
35460	Хүнсний материал	21,241,080.00	1,054,800.00
35470	Бусад хангамжийн материал	19,448,457.90	17,015,057.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,813,088,454.74</u>	<u>1,746,900,050.67</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>1,813,088,454.74</u>	<u>1,746,900,050.67</u>
392	Биет хөрөнгө	<u>1,741,518,854.74</u>	<u>1,663,417,450.67</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,695,924,746.23	1,695,924,746.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	-339,075,311.84	-412,097,588.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,500,000.00	21,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,500,000.00	-21,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	395,037,934.39	415,239,934.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	-177,694,424.64	-225,053,745.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	229,642,753.57	270,537,753.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-103,033,880.82	-121,850,687.57
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	150,000.00	150,000.00
39217	Ном	40,567,037.85	40,567,037.85
393	Биет бус хөрөнгө	<u>71,569,600.00</u>	<u>83,482,600.00</u>
39301	Програм хангамж	2,650,000.00	15,646,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,650,000.00	-3,733,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	71,569,600.00	71,569,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,232,366,287.56</u>	<u>2,009,567,209.16</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>17,321,500.00</u>	<u>25,291,507.52</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>17,321,500.00</u>	<u>25,291,507.52</u>
413	Өглөг	<u>17,321,500.00</u>	<u>25,291,507.52</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	913,116.27
4136	Бусад өглөг	<u>17,321,500.00</u>	<u>24,378,391.25</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	17,321,500.00	24,378,391.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,215,044,787.56</u>	<u>1,984,275,701.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>2,215,044,787.56</u>	<u>1,984,275,701.64</u>

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,223,869,576.73	1,223,869,576.73
51101	Өмч: - төрийн	1,223,869,576.73	1,223,869,576.73
512	Хуримтлагдсан үр дүн	720,261,644.76	489,492,558.84
51210	Өмнөх үеийн үр дүн	720,261,644.76	720,261,644.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-230,769,085.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	270,913,566.07	270,913,566.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,232,366,287.56	2,009,567,209.16

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,386,236,045.80	2,827,819,708.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,736,545.80	29,805,708.00
120	Нийтлэг татварын бус орлого	31,736,545.80	29,805,708.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,982,110.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,982,110.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	31,736,545.80	24,209,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	-	2,614,598.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,354,499,500.00	2,798,014,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,234,945,500.00	2,611,106,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,234,945,500.00	2,611,106,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	239,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	239,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	119,554,000.00	186,668,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	119,554,000.00	186,668,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,257,206,140.69	3,058,588,793.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,257,206,140.69	3,058,588,793.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,210,346,490.69	2,926,195,273.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	886,228,879.59	2,125,710,214.81
210101	Үндсэн цалин	585,155,082.62	1,193,113,512.40
210102	Нэмэгдэл	269,479,896.97	782,371,270.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	55,370,181.82
210104	Урамшуулал	31,593,900.00	94,855,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,581,442.43	263,312,964.16
210201	Тэтгэврийн даатгал	64,447,430.09	180,586,292.36
210202	Тэтгэмжийн даатгал	6,833,639.50	20,982,830.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,879,584.80	11,089,268.93
210204	Ажилгүйдлийн даатгал	2,994,495.19	10,143,454.36
210205	Эрүүл мэндийн даатгал	15,426,292.85	40,511,118.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,360,106.87	205,900,230.85

210301	Гэрэл, цахилгаан	7,856,241.52	21,623,377.49
210302	Түлш, халаалт	103,503,865.35	184,006,853.36
210303	Цэвэр, бохир ус	00.00	270,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,738,204.44	39,760,960.00
210401	Бичиг хэрэг	12,154,340.00	11,971,810.00
210402	Тээвэр, шатахуун	5,202,450.00	13,844,470.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,381,414.44	13,944,680.00
2105	Нормативт зардал	27,956,460.00	100,932,010.00
210502	Хоол, хүнс	27,956,460.00	100,932,010.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	169,500.00	2,782,000.00
210604	Урсгал засвар	169,500.00	2,782,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,888,000.00	3,910,000.00
210702	Дотоод албан томилолт	1,888,000.00	3,910,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,274,373.90	22,438,777.33
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	806,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,274,373.90	21,632,377.33
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,149,523.46	161,448,116.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	403,200.00	21,166,712.70
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,746,323.46	140,281,404.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,859,650.00	132,393,520.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,859,650.00	131,475,520.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,859,650.00	131,475,520.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	918,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	918,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	129,029,905.11	-230,769,085.92
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	129,029,905.11	-230,769,085.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,354,499,500.00	2,801,208,098.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	3,194,098.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	3,194,098.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	3,194,098.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,982,110.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	211,988.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,354,499,500.00	2,798,014,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,234,945,500.00	2,611,106,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,234,945,500.00	2,611,106,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	239,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	239,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	119,554,000.00	186,668,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	119,554,000.00	186,668,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,203,277,162.79	2,893,284,001.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,203,277,162.79	2,893,284,001.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,164,642,192.79	2,779,846,501.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	885,921,650.77	2,125,057,777.24
210101	Үндсэн цалин	588,287,437.17	1,210,809,880.06
210102	Нэмэгдэл	266,040,313.60	762,909,465.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	55,370,181.82
210104	Урамшуулал	31,593,900.00	95,968,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,888,671.25	263,312,964.44
210201	Тэтгэврийн даатгал	64,285,441.66	180,586,292.36
210202	Тэтгэмжийн даатгал	6,826,829.02	20,982,830.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,828,540.16	11,089,268.93
210204	Ажилгүйдлийн даатгал	3,829,352.10	10,143,454.64
210205	Эрүүл мэндийн даатгал	15,118,508.31	40,511,118.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,360,106.87	181,718,500.00
210301	Гэрэл, цахилгаан	7,856,241.52	21,623,377.49
210302	Түлш, халаалт	103,503,865.35	159,825,122.51
210303	Цэвэр, бохир ус	00.00	270,000.00
2105	Нормативт зардал	39,004,800.00	99,701,750.00
210502	Хоол, хүнс	39,004,800.00	99,701,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,644,500.00	4,032,000.00
210604	Урсгал засвар	2,644,500.00	4,032,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,274,373.90	29,356,299.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,787,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,274,373.90	26,569,299.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,548,090.00	76,667,210.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,448,190.00	64,145,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,099,900.00	12,522,010.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,634,970.00	113,437,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,634,970.00	112,519,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,634,970.00	112,519,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	918,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	918,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	151,222,337.21	-92,075,903.31
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	49,884,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	49,884,000.00

2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	49,884,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	49,884,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-49,884,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	151,222,337.21	-141,959,903.31
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	153,213,808.24	340,814,895.31
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	304,436,145.45	198,854,992.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,223,869,576.73	270,913,566.07	290,587,095.73	1,785,370,238.53
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,223,869,576.73	270,913,566.07	290,587,095.73	1,785,370,238.53
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	129,966,981.82	129,966,981.82
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,223,869,576.73	270,913,566.07	720,261,644.76	2,215,044,787.56
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,223,869,576.73	270,913,566.07	720,261,644.76	2,215,044,787.56
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,223,869,576.73	270,913,566.07	720,261,644.76	2,215,044,787.56
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-230,769,085.92	-230,769,085.92
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,223,869,576.73	270,913,566.07	489,492,558.84	1,984,275,701.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	340,814,895.31	-340,814,895.31
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,004,564,600.00	2,756,499,501.31	248,065,098.69
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,004,564,600.00	2,756,499,501.31	248,065,098.69
210	Бараа, үйлчилгээний зардал	2,883,602,200.00	2,643,980,001.31	239,622,198.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,331,296,800.00	2,125,057,777.24	206,239,022.76
210101	Үндсэн цалин	1,450,982,800.00	1,210,809,880.06	240,172,919.94
210102	Нэмэгдэл	807,289,600.00	762,909,465.36	44,380,134.64
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	-	55,370,181.82	-55,370,181.82
210104	Урамшуулал	73,024,400.00	95,968,250.00	-22,943,850.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	291,408,300.00	263,312,964.44	28,095,335.56
210201	Тэтгэврийн даатгал	198,157,700.00	180,586,292.36	17,571,407.64
210202	Тэтгэмжийн даатгал	23,312,700.00	20,982,830.03	2,329,869.97
210203	ҮОМШӨ ний даатгал	11,656,300.00	11,089,268.93	567,031.07
210204	Ажилгүйдлийн даатгал	11,656,300.00	10,143,454.64	1,512,845.36
210205	Эрүүл мэндийн даатгал	46,625,300.00	40,511,118.48	6,114,181.52
2105	Нормативт зардал	101,597,600.00	99,701,750.00	1,895,850.00
210502	Хоол, хүнс	101,597,600.00	99,701,750.00	1,895,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	43,378,400.00	42,352,299.63	1,026,100.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,039,700.00	2,787,000.00	252,700.00
210806	Мэдээллийн технологийн зардал	40,338,700.00	39,565,299.63	773,400.37
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	115,921,100.00	113,555,210.00	2,365,890.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,397,700.00	101,033,200.00	2,364,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,523,400.00	12,522,010.00	1,390.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,962,400.00	112,519,500.00	8,442,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,962,400.00	112,519,500.00	8,442,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	120,962,400.00	112,519,500.00	8,442,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,539,053,700.00	2,614,327,610.00	-75,273,910.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,539,053,700.00	2,611,106,500.00	-72,052,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,539,053,700.00	2,611,106,500.00	-72,052,800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	2,982,110.00	-2,982,110.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,982,110.00	-2,982,110.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	239,000.00	-239,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	239,000.00	-239,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	340,814,895.31	-340,814,895.31
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	198,854,992.00	-198,854,992.00

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	186,668,500.00	185,750,500.00	918,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	186,668,500.00	185,750,500.00	918,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	186,668,500.00	185,750,500.00	918,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	181,718,500.00	181,718,500.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	38,454,000.00	21,623,377.49	16,830,622.51

210302	Түлш, халаалт	142,967,500.00	159,825,122.51	-16,857,622.51
210303	Цэвэр, бохир ус	297,000.00	270,000.00	27,000.00
2104	Эд хогшил худалдан авах	4,950,000.00	4,032,000.00	918,000.00
210604	Урсгал засвар	4,950,000.00	4,032,000.00	918,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	186,668,500.00	185,750,500.00	918,000.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	186,668,500.00	185,750,500.00	918,000.00
	Орон нутгийн төсвөөс	186,668,500.00	185,750,500.00	918,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Багш мэргэжлийн хөгжлийг дэмжих хүүхэд бүрийн сурч хөгжих сургалтын таатай орчин бүрдүүлэн сургалтын чанар үр дүнд ахиц гаргах зорилго тавин ажиллаж байна. Ардын өв уламжлал, ёс заншил, зорилгод хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн тоглоом наадгайгаар дамжуулан бүтээлч үйлийн орчин бүрдүүлэн ард иргэдийн итгэл хүлээсэн инээж угтаж, сургуулийн өмнөх боловсролын сурагчдад эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд

- Боловсролын ерөнхий хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ хадалдан авах тухай хууль
- Хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 222,799.1 мянган төгрөгөөр буюу 9.98 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	340,814.9	198,855.0	-141,959.9
Авлага	580.2	628.9	48.7
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	77,882.7	63,183.3	-14,699.4
Үндсэн хөрөнгө	1,813,088.5	1,746,900.0	-66,188.5
Нийт хөрөнгө	2,232,366.3	2,009,567.2	-222,799.1
Өр төлбөр	17,321.5	25,291.5	7,970.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,215,044.8	1,984,275.7	-230,769.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,232,366.3	2,009,567.2	-222,799.1

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл 198,855.0 мянган төгрөг болж 141,959.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 628.9 мянган төгрөг болж 48.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 212.0 мянган төгрөгийн авлага барагдаж, 260.7 мянган төгрөгийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 63,183.3 мянган төгрөг болж 14,699.4 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материал 6,254.7 мянга, тусгай зориулалтын материалын зардал 6,021.6 мянга, хүнсний материал 212,221.2 мянга, аж ахуйн материалын

зардал 9,964.2 мянга, бичиг хэргийн материал 11,944.8 мянга, түлш, шатах тослох материал 13,844.5 төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд 274,950.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,746,900.0 мянган төгрөг болж 66,188.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 74,093.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардал 140,281.4 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Өглөгийн данс 7,970.0 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбогдсон өглөг 913.1 мянга, байгууллагад төлөх өглөг 7,056.9 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Энэ нь Эко дулаан хангамж ХХК-д төлөх халаалтын санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,984,275.7 мянган төгрөг болж 230,769.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 49,884.0 мянга, бусад эх үүсвэрээс 21,509.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант онд 140,281.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,918,223.6 мянга, орон нутгийн төсвөөс 186,668.5 мянган төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвөөс санхүүжих төсвийн төслийн саналыг 86,341.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 3,004,564.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны улсын төсвөөс 465,510.9 мянган төгрөгөөр бууруулан тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,539,053.7 мянган төгрөгийг баталсан байна. Мөн орон нутгийн төсвөөс 186,668.5 мянган төгрөг баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,611,106.5 мянга, орон нутгийн төсвөөс 185,750.5 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 2,982.1 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 239.0 мянган төгрөг, нийт 2,800,078.1 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлсэн урсгал үйл ажиллагааны зардалд 2,942,250.0 мянган төгрөгийг зарцуулж, 198,855.0 мянган төгрөгийн харилцахын эцсийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,942,250.0 мянган төгрөг буюу 105.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 206,239.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 28,095.3 мянга, нормативт зардлыг 1,895.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 2,365.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 113,555.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 918.0 мянга, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг 75,273.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ /80226/	3,468.7	3,468.7	0	100%
2	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/	186,668.5	185,750.5	918.0	99.5%

3	Хүүхэд хамгаалал /80233/	3,568.0	3,344.0	224.0	93.7%
4	Сургалт семинар /80312/	2,036.9	2,036.9	0	100%
5	Эрүүл мэндийг дэмжих /81605/	3,797.5	3,797.5	0	100%
6	Үдийн цай /81801/	120,962.4	112,519.5	8,442.9	93.0%
7	Дотуур байр /81806/	460,105.3	409,422.5	50,682.8	88.9%
8	Хүүхдэд ээлтэй орчин /81816/	54,209.0	54,209.0	0	100%
9	Боловсролын байгууллагын багш ажилтаны мэргэжил дээшлүүлэх/81823	10,075.8	10,075.8	0	100%
10	Бичиг үсгийн боловсрол/81827/	17,490.2	3,012.0	14,478.2	17.2%
11	Боловсролын стандарт/81834	2,240,800.3	2,090,606.7	150,193.6	93.3%
12	Сургалтын хэвийн үйл ажиллагаа/81835/	70,286.0	49,380.0	20,906.0	70.3%
13	Сурах бичгийн түрээс /81848/	3,039.7	2,787.0	252.7	91.7%
14	Сургуулийн нэмэлт хөтөлбөр /81875/	12,373.8	11,600.4	773.4	93.7%
15	Нэмэлт /83603/	2,390.0	239.0	2,151.0	10.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5, 2.6-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	15,646.0	15,646.0	Conva pro, Comtasia, Office, Архив бичиг хэрэг хөтлөлтийн программ, Номын сангийн программ зэрэг 5 программ ашиглаж байна
2	Унаа, хоолны зардал	55,370.2	55,370.2	Ажилтнуудад хоолны хөнгөлөлт 5.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар, хурал цуглаан	2,036.0	2,036.0	Тус байгууллага нь тайлант онд сургалт, семинар, хурал цуглааны зардалд 2,036.0 мянган төгрөг зарцуулсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	0.0	Гадаад томилолтын зардал байхгүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0.0	0.0	Орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл, мэдээлэл	0.0	0.0	Хэвлэл, мэдээллийн зардал байхгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд 2025 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар багцын 275,696.8 мянган төгрөгийн 2 тендер зарласан байна. Үүнд:

1. Үдийн хоолны хүнсний материал нийлүүлэх тендерийн Багц 1 мах, махан бүтээгдэхүүн 31,816.0 мянга, Багц 2 түүхий эд материал 22,144.9 мянга, Багц 3 төмс, хүнсний ногоо 12,420.0 мянга, Багц 4 жимс, жимсгэнэ 30,595.0 мянга, Багц 5 сүү, сүүн бүтээгдэхүүн 53,955.8 мянга, нийт 140,292.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалтын аргаар шалгаруулж худалдан авалт хийсэн байна.
2. Дотуур байрны хүүхдийн хүнсний материал нийлүүлэх тендерийн Багц 1 мах махан бүтээгдэхүүн 44,803.0 мянга, Багц 2 түүхий эд материал 15,725.0 мянга, Багц 3 төмс, хүнсний ногоо 11,440.0 мянга, Багц 4 жимс, жимсгэнэ 13,185.0 мянга, Багц 5 сүү, сүүн бүтээгдэхүүн 52,524.0 мянга, нийт 137,677.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалтын аргаар шалгаруулж худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,471,152.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 24,711.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 19,769.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,058,588.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 30,585.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 24,468.7 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны цахим хуудаст Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 87,102.0 мянган төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,783,594.1 мянган төгрөгийн 20 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 32,852.5 мянган төгрөгийн 3 шийдвэрийн мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлангийн 137,681.5 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 262,583.9 мянган төгрөгийн 22 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 44,364.0 мянган төгрөгийн 10 шийдвэрийн мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө байршуулах 288,613.2 мянган 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна. Харин 6,976.2 мянган төгрөгийн төгрөгийн 2 алдаа илэрснийг тайлант хугацаанд залруулга хийлгэсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,640,522.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 3,731.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 3,636,791.2 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

1. Тэтгэвэр тогтоолгосон бага ангийн багш албан тушаалтай ажилтанд цалинг бодож олгохдоо нийгмийн даатгалын шимтгэлийг 558.7 мянган төгрөгөөр илүү суутгаж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 дахь “Бүх өр төлбөр” Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсанд өглөгөөр бүртгүүлэн залруулга хийлээ.
2. Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь 3-р сарын цалинг бодож олгохдоо технологийн багш албан тушаалтай ажилтанд олгосон урьдчилгааг суутган тооцоогүй байсанд 260.7 мянган төгрөгийн цалингийн өр үүссэнийг дараа саруудын цалингаас нь суутгаж аваагүй тул авлагыг данс бүртгэлд тусгаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул авлагаар бүртгүүлэн залруулга хийлгэлээ.
3. Өмнөх оны ажилчидтай холбогдсон 212.0 мянган төгрөгийн авлагыг бэлэн мөнгөөр барагдуулсан орлогыг данс бүртгэлд тусгаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5 дахь заалтад “Бүх орлого” Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул орлого бүртгүүлэн залруулга хийлээ.
4. Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар ирсэн 2,700.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул хөрөнгө орлогод бүртгүүлэн залруулга хийлгэлээ.

5.1 Зөвлөмж

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 87,102.0 мянган төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,783,594.1 мянган төгрөгийн 20 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 32,852.5 мянган төгрөгийн 3 шийдвэрийн мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлангийн 137,681.5 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 262,583.9 мянган төгрөгийн 22 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 44,364.0 мянган төгрөгийн 10 шийдвэрийн мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө байршуулах 288,613.2 мянган 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өглөг тусгаагүй.	1	558.7	1	558.7			1	558.7				
Авлага тусгаагүй.	1	260.7	1	260.7			1	260.7				
Орлого бүртгээгүй.	1	212.0	1	212.0			1	212.0				
Хөрөнгө орлогод аваагүй.	1	2,700.0	1	2,700.0			1	2,700.0				
Дүн	4	3,731.4	4	3,731.4			4	3,731.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим хуудаст 30 мэдээлэл байршуулаагүй, 33 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.	1	3,636,791.2							1	3,636,791.2		

Дүн	1	3,636,791.2				1	3,636,791.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Дүн							
Нийт дүн							

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.БАТСҮХ/

2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр